



Хууль эрх зүй

МӨНГӨ "УГААХ" ГЭЖ ЮУ ВЭ?

Хүн төрөлхтөний амь амьдрал, нийгэм улс төр эрх зүйн бүхий л хүрээнд онцгой түргэнээр мэдрэгдэж буй хорт үр дагавартай олон юмны илрэл, үйл явцын дотроос эрх зүйч мэргэжилтэй хилийн офицер болохоор суралцагчид эртнээс ойлгож мэдвэл зохих онцгой хэд хэдэн цогц гэмт зохион байгуулалт, үйл ажиллагаанууд байдаг. Үүний нэг нь мөнгө "угаах" үйлдэл юм.

Дэлхий нийтэд илэрхий болсон мөнгө "угаах" явдал өнөөдөр улс түмний анхаарлын төвд байна. Олон улсын эрдэмтдийн дүгнэж байгаагаар зохион байгуулалттай гэмт хэргийн орлого олон зуун тэрбум америк доллар болдог бөгөөд хууль бусаар олсон мөнгөний эргэлт нь жилд хэд хэдэн трилион долларт хүрдэг болно. Эдгээр нь гэмт аргаар олсон мөнгө юм. Дэлхий дахины хэмжээнд гэмт аргаар олж байгаа мөнгөний зонхилох хэсгийг хар тамхины наймаа бүрдүүлдэг бөгөөд басхүү тодорхой хэсэг нь зэвсэг нууцаар худалдах санхүүгийн хуурамч үйл ажиллагаа стратегийн түүхий эд, эрчим хүч түлшний далд наймаа, татварын болон эдийн засгийн гэмт хэргийн замаар олсон хөрөнгө эзэлж байна.

Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлгүүд гэмт хэргийн үр дүнд буюу хууль бус замаар олсон их хэмжээний бэлэн ба бэлэн бус мөнгө хяналтын байгууллагын анхаарлыг татахгүйгээр ашиглах бололцоотой учир уг мөнгөө албан ёсны болгох, өөрөөр хэлбэл бохир мөнгөө угаах шаардлагатай болдог. Тийм болохоор мөнгө "угаах" гэдэг нь гэмт хэргийн үр дүнд буюу хууль бусаар олсон их хэмжээний мөнгийг албан ёсны баталгаатай санхүүгийн эх үүсвэртэй болгон хувиргаж банкны системээр дамжуулан орлогын эх үнэнийг нуухад чиглэсэн ажиллагааг хэлнэ.

Мөнгө "угаах" үйлдэл нь гурван үе шаттай явагддаг байна. Хууль бусаарх замын энэ мөнгийг хэн нэгэн чинээлэг хүнтэй тохиролцож түүнд шилжүүлнэ. Чухам яагаад чинээлэг хүнийг сонгох хэрэгтэй нь нэгэнт их хэмжээний мөнгөтэй хүн аль нэг банктай харьцахад сэжиг төрүүлэхгүй, хялбар байх учиртай. Хууль бус мөнгөтэй этгээдтэй тохиролцогч нь ихэвчлэн зах зээл дээр ноёрхсон хэт ашиг олох зорилгоор байгуулсан үйлдвэрийн эздийн монополь нэгдэл байна. Тэдгээр нь мөнгийг бага багаар нь өөр өөр банкинд

хадгална. Бас мөнгөний чекийг бусдад худалдаж болох бөгөөд ингэснээрээ хаа нэг банкинд сэжиггүйгээр хадгалагдах боломжийг олно. Энэ бол мөнгө "угаах" үйл ажиллагаанд байршуулалт гэгдэх шатны ажиллагаа болно.

Дараа нь тэд орлогыг хууль бусаар орж ирсэн гэдгийг далдлахын тулд санхүүгийн дэс дараатай иж бүрэн хэлэлцээр хийсэн баримтыг бүрдүүлэн, хууль бус эх үүсвэртэй нь холбогдолгүй болгоно. Энэ бол уг үйл ажиллагааны булзааруулалт гэдэг шатны ажиллагаа бөгөөд санхүүжилт, шалгалт хийхэд хүндрэл бэрхшээл учруулах, нэр хаяггүй болгож байгаа хэрэг юм. Эцэст нь баримт бүрдүүлэх үйл явц амжилттай дуусвал хууль бус мөнгийг ердийн л бизнесийн орлого мэтээр санхүүгийн эргэлтэд оруулна. Хууль бусаар олсон мөнгийг гадна талаас нь сэжиглэгдэхээргүй болгож, хууль ёсны бизнесийн хүрээнд оруулсан энэ шатыг интеграцчлах гэнэ. Энэ хэрэг явдал тэр хэмжээнд хүрсэн бол илрүүлэх нь тун ч боломжгүй болсон байна.

Мөнгө "угаах" үе шатууд дээрх дараалалаар явагдах бөгөөд зарим улсад аль нэгэн шат тухайлбал гурав дахь нь хийгдээгүй байх тал бий.

Мөнгө "угаах" ажиллагаа нь алив гэмт хэргийн бүлэглэлүүдэд эдийн засаг, санхүүгийн талаар хүчирхэгжих боломжийг олдгоороо үндэсний эдийн засагт болон ардчиллын тогтолцоонд ихээхэн аюулыг буй болгоно. Сүүлийн арван жилийн хугацаанд дэлхийн олон орон уг үйлдэл, ажиллагааны эсрэг янз бүрийн арга хэмжээ авч улмаар хамтран ажиллах бодитой ахицад ойртож буй тал бий юм.

Одоо бид мөнгө "угаах" үе шатуудыг товч боловч үзье.

а. Байршуулах Гэмт хэргийн бүлэглэлийн хувьд хамгийн төвөгтэй, хариуцлагатай үе нь юм. Гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг юуны өмнө бэлэн мөнгийг санхүүгийн системд оруулах явдал байна. "Бохир" мөнгө байршуулах дараахь аргууд хэрэглэгдэнэ.

1. Хадгаламж хийх тусгай хүмүүсийг ашиглах
2. Журмаас гадуур банкны ажилтнуудыг худалдан авах
3. Бэлэн мөнгө банкинд хийхэд хязгаарлалт байдаггүй тул хууль бусаар их мөнгө оруулах
4. Валют солих цэг, хөрөнгө оруулалтын компани тоглоомын газар зэрэг гэмт бүлэглэлийн хяналтад байдаг газруудыг ашиглах
5. Гэмт хэргийн орлогыг албан ёсны орлоготой холилдуулах замаар зохицуулах
6. Татварын эргэлт, үйл явцыг ашиглах
7. Халхавчийн пүүсүүдийг ашиглах

б.Булзааруулах Уг үйл ажиллагаа нь гэмт хэргийн замаар олсон мөнгийг санхүүгийн системд оруулж, бэлэн бус хэлбэрт шилжүүлэхээс эхэлнэ. Мөнгөний жинхэнэ эзнийг нуух зорилгоор санхүүгийн элдэв үйлдэл хийнэ. Олон олон үйлдлийн дараа түүний жинхэнэ эх тогтооход хүндрэлтэй болно. Мөнгө шилжүүлэх пүүс компани ч ашиглагдахын гадна их хэмжээгээр хийх хууль ёсны гэрээ хэлцлүүдийн төлбөр тооцоог хийх электрон дамжуулагчдыг ч өргөн ашиглана.

в.Интеграцчлах "Бохир" мөнгөний жинхэнэ эзнийг нуусны дараа мөнгийг хэрхэн ашиглах асуудал тулгарна. Иймээс уг хөрөнгийг үйлдвэр санхүүгийн байгууллага, үнэт цаас, эдлэл, үл хөдлөх хөрөнгө, газар худалдан авах зэргээр хууль ёсны бизнест оруулна. Энэ шат буюу хууль бус мөнгийг ил эдийн засагт оруулах нь өмнөх хоёр шатны ажиллагааны үеийнхээс илүү их аюултай байдаг талтай. Чухамдаа зохион байгуулалттай гэмт хэрэгтнүүдээс хууль тогтоох, мөн гүйцэтгэх засаглалын байгууллагуудад үзүүлэх нөлөөг ихэсгэхийн дээр улс төр, эдийн засгийн тогтолцоонд нэвтэрдэгтэй холбоотой болно. Мөнгө "угаах" үйл ажиллагаа нь банк, санхүүгийн салбарын хууль тогтоомжийг байнга зөрчдөг бөгөөд гэмт хэргийн орлогыг ил болгохын тулд дараахь ажиллагааг хийнэ. Үүнд:

1. Тайлан тэнцлийг будлиантуулах
2. Төрийн албан хаагч, мөн хууль ёсоор бизнес хийгчдийг худалдан авах, айлган сүрдүүлэх
3. Уг ажиллагааг эрхлэх гадаад харилцаатай тусгайлсан байгууллагуудтай байх

Орчин үеийн шинжлэх ухаан, харилцаа холбооны хөгжилт, санхүү, банкны системийн компьютержилт нь мөнгө "угаах" үйлдэл олон улс оронд гарах нөхцөлийг бүрдүүлж байгаа юм. Улс орон дамжсан гэмт бүлэглэлүүдийн үйл ажиллагааны хүрээ улам тэлж байгаатай холбогдуулан, түүнтэй тэмцэх байгууллагуудаас тавих хяналтыг дээшлүүлэх, хамтын ажиллагаагаа сайжруулахыг улс орны дотоодод ч олон улсын хэмжээнд ч зайлшгүй шаардаж байна. Иймээс гэмт хэрэг, улс орон дамнасан шинж чанартай болж, эдийн засаг санхүүгийн салбаруудад гүнзгийгээр нэвтэрч байгаа өнөө үед энэ аюулын эсрэг олон улсын хэмжээнд хамтран ажиллах, арга эвээ олох үндэс онцгой чухал гэж үзэж байгаа бөгөөд тэдгээрийн анхны алхам нь 1988 онд батлагдсан "Хар тамхи, сэтгэл мэдрэлд нөлөөлөх бодис наймаалахын эсрэг" конвенц болно.

Мөнгө "угаах"-тай тэмцэх асуудал олон улсын чанартай доорхи бичиг баримтад туссан байна. Энд мөнгө "угаах" гэмт хэргийн

замаар олсон орлогыг илрүүлэх, хураан авах тухай Европын зөвлөлийн конвенц, санхүүгийн системийг мөнгө "угаах"-д ашиглахаас урьдчилан сэргийлэх тухай Европын зөвлөлийн удирдамж, банкны үйл ажиллагаанд хяналт тавих журам, арга барил, зарчмын тухай Базедийн хорооны мэдэгдэл зэрэг байдаг. Дэлхийн эдийн засгийн дээд хэмжээний уулзалтанд оролцогчдын шийдвэрээр байгуулагдсан санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хороо нь мөнгө "угаах"-тай тэмцэх ажлын хөтөлбөр боловсруулсан болно.

Тэмцлийн эхэн шатны үйл ажиллагаанууд нь гэмт хэрэгтний бүлэглэлүүдэд мөнгө "угаах" шинэ суваг, арга заль тасралтгүй эрэлхийхэд хүргэнэ.

Иймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудал "Хоолой дээр тээглэсэн яс" хэвээр байх болно гэдгийг эрдэмтэн шинжээчид хүлээн зөвшөөрч байгаа юм.

Саяавтархан төвийн нэгэн хэвлэлд "Мэргэжилтнүүдийн тооцоолсноор жилд дундажаар олон улсын зах зээлд 500.000 сая ам.доллараар үнэлэгдэх бохир мөнгө орж ирдэг" гэж дурдсан байна. Манай орны тухайд чухамдаа жилд хэдий хэмжээтэй бохир мөнгө ямар байдлаар орж ирж байгааг тодорхойлох бүү хэл "Мафи" бий эсэх талаар чангахан тууштай үг сонсогдохгүй байгаа билээ.

Эрх зүйн тэнхимийн багш Л.Сандагсүрэн